

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД

Ерөнхий мэдээлэл

- Хөгжлийн бэрхшээлийн холбоотой асуултууд хүн амын тооллогод 2010 онд анх удаа багтсан ба үүнээс өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх статистик мэдээ нь нэг удаагийн судалгаа, эсвэл боловсрол, эрүүл мэндийн салбарын дүн мэдээ гэх мэт ялгаатай арга зүйгээр цуглуулсан мэдээлэлд үндэслэж байв. 2010 онд нийт 108.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн тоологджээ.
- 15 хүртэлх насын хөгжлийн бэрхшээлтэй 9.5 мянган хүүхэд байгаа нь энэ насын бүх хүүхдийн 1.3 хувь, нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 8.7 хувь юм. Үүнд 2.5 мянга нь бага насын буюу 6 хүртэлх насын хүүхэд, 7.0 мянга нь 6-14 насыхан байна. Хөгжлийн бэрхшээлтэй З хүүхэд тутмын 2 нь төрөлхийн, 1 нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.
- 15-24 насын хөгжлийн бэрхшээлтэй 14.3 мянган залуучууд тоологсон нь энэ насын нийт хүн ам (549.8 мянга)-ын З орчим хувь, нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 13 хувь юм. Тэдний 56 хувь нь төрөлхийн, 44 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.
- Хүйсийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй 24 хүртэлх насын бүлэгт эрэгтэйчүүд ялимгүй их буюу 56:44 хувийн харьцаатай байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн бүлэгт хүйсийн энэ харьцаа тууштай хадгалагдаж байгаа бол олдмол хөгжлийн бэрхшээлийн бүлэгт 0-14 насанд 57:43 байсан харьцаа 15-24 насанд 61:39 болж, цаашид наас ахихын хэрээр эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсээр зөвхөн 70 ба түүнээс дээш насын бүлэгт олдмол хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тоо илүү болж байна. Ер нь олдмол хөгжлийн бэрхшээл нас ахихын хэрээр нэмэгдэж, үүнд эрэгтэйчүүдийн тоо нэмэгддэг хандлагыг осол гэмтэл, хордлого зэрэг хөгжлийн бэрхшээлд хүргэх хүчин зүйлд эмэгтэйчүүдээс илүү өртөх магадлалаар тайлбарлажээ.

Боловсрол

- 2010 онд 2-5 насын 202.4 мянган хүүхдээс хөгжлийн бэрхшээлтэй 2.0 мянган хүүхэд тоологджээ. Хөгжлийн бэрхшээлтэй бага насын хүүхдийн 39 орчим хувь буюу 780 нь цэцэрлэгт хамрагдаж байв. Гэтэл энэ насын нийт хүүхдийн 60 хувь нь цэцэрлэгт явдаг гэж бүртгэгдсэнтэй харьцуулбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт бусад хүүхдээс 1.5 дахин бага байна.
- Харин БШУЯ-ны статистикийн мэдээгээр 2009-2010 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 1156 хүүхэд цэцэрлэгт явж байгаа гэж бүртгэгдсэн нь хүн амын тооллогын дүнгээс нэлээд зөрүүтэй байгаа юм. Энэ хоёр судалгаа нь өөр өөр арга зүй хэрэглэж байгаагаас дүнгийн зөрүү гарсан байх магадлалтай ч арга зүйгээ тайлбарлаагүй байна.
- Цэцэрлэгт явж байгаа хүүхдүүдийн хувьд хот, хөдөөгийн ялгаа ажиглагдахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон нийт 2-5 насын бүлгийн 75 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 25 орчим хувь нь хөдөө орон нутагт байгаа нь боловсролын үйлчилгээний хүртээмж хот, хөдөөд ялгаа байгаа гэсэн үг бус, харин хүн амын суурьшилтын тусгал байна.

Учир нь энэ насны нийт хүүхдийн 68 хувь нь хотод, 32 хувь нь хөдөөд амьдарч байгаа ажээ.

- Цэцэрлэгт явж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дотор хүйсийн хувьд эрэгтэй хүүхдүүд, насын бүлгийн хувьд 5 настай хүүхдүүд олонх нь байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй 6-14 насны хүүхдүүдийн 60 орчим хувь нь бичиг үсэгтэй байна. Хүйсийн харьцааны хувьд сургуулийн өмнөх боловсролын түвшинээс л ажиглагдсан эрэгтэй хүүхдийн тоо илүү байх хандлага тууштай хадгалагдаж байна.
- Боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 93 хувь нь бага боловсролтой, харин дөнгөж 7 хүрэхгүй хувь нь суурь боловсролтой байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй 6-14 насны хүүхдийн 67 хувь нь ерөнхий боловсролын энгийн сургууль болон тусгай сургуульд суралцаж байгаагаас 59 орчим хувь нь хотод, 41 хувь нь хөдөө орон нутагт бүртгэгджээ. Харин Монгол улсын хэмжээнд нийт 6-14 насны 41, 0 орчим мянган хүүхэд бүртгэснээс 40,0 мянга орчим буюу 97 хувь нь сургуульд сурч байна.
- 15-24 насны залуучуудын хувьд 28 хувь нь сургуульд сурч байна. Нийт 15-24 насны залуучуудын 53 хувь нь аль нэг шатны сургуульд сурч байгаатай харьцуулбал

хөгжлийн бэрхшээлтэй залуус боловсролд хамрагдалтаараа үе тэнгийнхнээсээ 1,5 дахин бага үзүүлэлттэй гарч байна.

- Хүйсийн хувьд нийт хөгжлийн бэрхшээлтэй 15-24 насны залуучуудын дөнгөж 6 хувийг бүрдүүлж байгаа дээд боловсролтой хүмүүсийн хүйсийн харьцаа тэнцүү, харин тусгай мэргэжил, техник мэргэжилт, бүрэн дунд, суурь, бага боловсролтой хүмүүсийн дунд эрэгтэйчүүд давамгай байна.
- Арваас дээш насын буюу бага боловсрол дүүргэсэн байх насын хөгжлийн бэрхшээлтэй 103.0 мянган хүнээс 22 хувь (22.7 мянга) нь боловсролгүй, 14.5 хувь (15.0 мянга) нь бичиг үсэг мэддэггүй гэж бүртгэгджээ. Гэтэл арав, түүнээс дээш насын нийт хүн амын 7 хувь нь боловсролгүй, 1.7 хувь нь бичиг үсэггүй байгаа ажээ.
- Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 6-аас дээш насын иргэдийн дөнгөж 7 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой, 46 орчим хувь нь бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой, 47 хувь нь огт боловсрол эзэмшээгүй байна. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 22 хувь нь бүрэн дундаас дээш, 66 орчим хувь нь бүрэн дунд ба түүнээс доош шатны боловсролтой бол үлдсэн 12 гаруй хувь нь боловсролгүй байна. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дотор төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрх илүү их хязгаарлагддаг хандлага илэрч байна.

Үндсэн эх сурвалж

1. Монгол улсын үндэсний статистикийн хороо (2011). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого. Сэдэвчилсэн судалгаа 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд. Улаанбаатар: Интерпресс
2. Монгол улсын үндэсний статистикийн хороо (2011). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого. Сэдэвчилсэн судалгаа 9. Хүүхэд залуучууд. Улаанбаатар: ВСI
3. Боловсрол, шинжлэх ухааны яам. 2009-2010 сургуулийн өмнөх боловсролын статистик мэдээ. <http://www.meds.gov.mn/preschooleducation/2/5> хаягаас 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдөр авав.